



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/130/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: Э.Нандинчимэг

Утас: 7000-3775 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗТХС	Зам Тээвэр Хөгжлийн Сайд
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



	Агуулга
Аудитын гэрчилгээ	1
Аудитын тайлан.....	3
2.1. Оршил.....	3
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	3
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	4
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	5
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	7
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	8
3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	8
3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	9
3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
3.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

Ауд. д. 27 № АОО

танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520122

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтын дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.1. Оршил

Хөлөнбуйр сумын цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг эрхлэгч М.Баярмагнай танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөлөнбуйр сумын цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөлөнбуйр сумын цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 26-наас 2020 оны 02 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Э.Нандинчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Хөлөнбуйр сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хөлөнбуйр сумын Цэцэрлэгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хүүхэд нэг бүрийн хөгжил төлөвшилд цэцэрлэг, олон нийтийн байгууллага, багш, эцэг эх асран хамгаалагчийн үүрэг оролцоо, хамтын ажиллагаа, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, хүүхэд хөгжих сургалтын таатай орчинг бүрдүүлэн, хичээл сургалтын үйл ажиллагааг чанартай зохион байгуулах”-д оршино.

Цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ: Үүнд:

- Багшийн мэргэжлийн ур чадвар арга зүйг дэмжих, хичээл сургалтын үйл ажиллагааг чанартай зохион байгуулах
- Цэцэрлэгийн үзэл баримтлал, сургалтын хөтөлбөрийг засан сайжруулж, барга үндэсний өв соёл зан заншилд тулгуурлан боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
- Хүүхэд бүрийг өөрийн хувийн онцлогийг дэмжиж, авьяас чадварыг нэхөгжүүлэх
- Хүүхдийн хөгжлийг бодитой үнэлэх, хичээл сургалтын үйл ажиллагааны төлөвлөлтөнд тусган чанартай хэрэгжүүлэх
- Багшид мэргэжлийн онол арга зүйн зөвөлгөө дэмжлэг туслалцаа үзүүлэх

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Хөлөнбуйр сумын цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байна.

Хөлөнбуйр сумын цэцэрлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Axploger” программ хангамж ашигладаг байна.

Хөлөнбуйр сумын цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөлтийн үе шатанд 31 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 274,680.7 мянган төгрөгөөс тооцон 5,493.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, гүйцэтгэлийн үе шатанд хэвээр баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хөлөнбуйр сумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 38,654.6 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт үндсэн хөрөнгийн элэгдэл данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/ мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	633.45	153.25	(480.21)
Бараа материал	38,951.18	35,349.48	(3,601.70)
Үндсэн хөрөнгө	1,337,187.74	1,339,414.74	2,227.00
Хуримтлагдсан элэгдэл	(73,894.55)	(110,694.32)	(36,799.77)
Нийт хөрөнгө	1,302,877.82	1,264,223.15	(38,654.67)
Өр төлбөр	1,967.25		(1,967.25)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,300,910.56	1,264,223.15	(36,687.42)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,302,877.82	1,264,223.15	(38,654.67)

Бараа материалын дансны үлдэгдэл 3,601.7 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны түлээ нүүрсийг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,227.0 мянган төгрөгөөр өссөн нь Халаалтын тогооны усанд капитал засвар хийж, угаалгын машин авсантай холбоотой байна.

Өмнөх оны өр төлбөр дансны үлдэгдэл 1,967.2 мянган төгрөгөөр буурсан нь ХХОАТ өр болон үйлдвэрчний эвлэлийн өр төлбөрийг тайлант онд барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,264,223.1 мянган төгрөг болж 38,654.6 мянган төгрөгөөр буурсан нь Үндсэн хөрөнгийн элэгдлээс шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 235,544.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 210,244.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 25,300.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 235,542.4 мянган төгрөг буюу 99.99 хувьтай байна.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 31 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд эрсдэл тогтоож 31 эрсдэл тодорхойлж нийт 31 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 15,321.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 14,510.3 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 811.2 мянган төгрөгийн төлбөрийн 2 акт тогтоов. Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Аудитаар дараах 15,321.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Тендерээс шалгаран байгууллагатай хийсэн гэрээний үнэ нь гүйцэтгэлээрх худалдан авалтын үнээс 302.9 мянган төгрөгөөр илүү төлсөн нь Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41.1 дэх хэсэгт “Худалдан авах гэрээнд бэрчлөлт хийхийг хориглоно.” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Шатахууны 508.3 мянган төгрөгийн зардлын анхан шатны баримтгүй бүртгэлд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 дахь хэсэгт “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дэх “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудад нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

3. Тайлант хугацаанд гарсан зардлаас 14,296.4 мянган төгрөгийн зардлыг и-баримт цахим системд бүртгүүлээгүй нь СС-ын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөх гэсэн тушаалыг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

4. Санхүүгийн үр дүнгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан дахь хоол хүнсний зардлыг 213,9 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 41.2.3 дэх “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудад нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

- ✓ Худалдан авалтын гэрээний нэгжийн үнэ, түүний өөрчлөлтийг нягтлан шалгах.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Хөлөнбуйр сумын Цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 136 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хөлөнбуйр сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Хөлөнбуйр сумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын рүүдэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	39,584,633.04	35,502,733.04
33	АВЛАГА	633,453.34	153,248.34
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	633,453.34	153,248.34
35	БАРАА МАТЕРИАЛ	38,951,179.70	35,349,484.70
351	Түүхий эд материал	73,400.00	73,400.00
35130	Эм боох материал	73,400.00	73,400.00
354	Хангамжийн материал	38,877,779.70	35,276,084.70
35410	Бичиг хэргийн материал	3,460,526.70	3,690,126.70
35420	Аж ахуйн материал	25,338,383.00	29,493,023.00
35440	Түүлш, шатах тослох материал	7,878,047.00	-
35460	Хүнсний материал	284,298.00	70,410.00
35470	Бусад хангамжийн материал	1,916,525.00	2,022,525.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,263,293,184.12	1,228,520,413.21
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,263,293,184.12	1,228,520,413.21
392	Биег хөрөнгө	1,257,697,184.12	1,223,077,413.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,240,988,409.12	1,242,788,409.12
39202	Хуримтлагдсан элэгдэл	(25,063,677.36)	(49,459,117.98)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	30,087,165.00	30,467,165.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(11,296,451.46)	(16,331,703.23)
39207	Тавилга, аж ахуйн эд хотшил	24,271,162.00	24,271,162.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,119,296.98)	(21,509,875.22)
39214	Бусад үндсэн хөрөнгө	36,245,000.00	36,245,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(18,415,126.20)	(23,393,626.48)
393	Биег бус хөрөнгө	5,596,000.00	5,443,000.00
39301	Програм хангамж	765,000.00	765,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(153,000.00)	(306,000.00)
39303	Бусад биег бус хөрөнгө	4,984,000.00	4,984,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I-II	1,302,877,817.16	1,264,023,146.25
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,967,253.85	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,967,253.85	0.00
413	Өглөг	1,967,253.85	0.00
41310	Ажилчинтай холбогдсон өглөг	1,765,467.12	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	96,515.00	-
4136	Бусад өглөг	105,271.73	-
41361	Байгууллагад төлөх өглөг	1,000.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	104,271.73	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,300,910,563.31	1,264,023,146.25
51	Засгийн газрын хувь оролцоо	1,300,910,563.31	1,264,023,146.25
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	81,346,141.00	81,346,141.00
51101	Өмч: - төрийн	81,346,141.00	81,346,141.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,156,983,174.55	1,120,095,757.49
51210	Өмнөх үеийн үр дүн	1,156,983,174.55	1,156,983,174.55
51220	Тайлант үеийн үр дүн	-	(36,887,417.06)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	62,581,247.76	62,581,247.76
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V	1,302,877,817.16	1,264,023,146.25

3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	223,222,986.00	237,793,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,153,086.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	15,153,086.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,153,086.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	15,153,086.00	-
13	ГУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТНИЙ ОРЛОГО	208,069,900.00	237,793,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	203,657,000.00	212,424,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	2,180,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	203,657,000.00	210,244,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,412,900.00	69,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,092,900.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	320,000.00	69,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	25,300,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	25,300,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	238,310,170.23	274,680,717.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	238,310,170.23	274,680,717.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	238,117,836.93	274,679,139.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	128,568,852.12	150,168,483.36
210101	Үндсэн цалин	128,568,852.12	150,168,483.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,763,588.09	19,567,682.79
210201	Тэтгэврийн даатгал	10,926,713.28	13,562,827.87
210202	Тэтгэмжийн даатгал	1,013,967.92	1,594,330.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,267,459.91	1,237,064.17
210204	Ажилгүйдлийн даатгал	232,313.36	288,496.41
210205	Эрүүл мэндийн даатгал	2,323,133.62	2,884,964.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,814,661.00	25,859,532.00
210301	Гэрэл, цахилгаан	4,977,201.00	4,413,925.00
210302	Түлш, халаалт	12,777,460.00	19,777,907.00
210303	Цэвэр, бохир ус	60,000.00	1,667,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,711,150.00	2,112,950.00
210401	Бичиг хэрэг	756,700.00	606,300.00
210402	Тээвэр, шатахуун	230,100.00	657,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	455,000.00	426,800.00
210404	Ном, хэвлэл	-	60,600.00
210406	Бага үнэтэй, түргэн эзгдэх, ахуйн эд зүйлс	2,269,350.00	361,650.00
2105	Нормативт зардал	38,709,202.00	35,785,710.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	99,500.00	200,000.00
210502	Хоол, хувс	38,609,702.00	35,019,710.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	566,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	3,521,410.00
210604	Урсгал засвар	-	3,521,410.00
2107	Томилголт, зочны зардал	208,000.00	300,600.00
210702	Дотоод албан томилголт	208,000.00	300,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	410,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	230,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,342,383.72	36,952,770.91
210903	Үндсэн хөрөнгийн эзгдэл, хорогдол	33,342,383.72	36,952,770.91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	192,333.30	1,578.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,578.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,578.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	192,333.30	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	192,333.30	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(15,087,184.23)	(36,887,417.06)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	180,050.00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	180,050.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(180,050.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(15,267,234.23)	(36,887,417.06)

3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	208,069,900.00	237,413,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТГИЙН ОРЛОГО	208,069,900.00	237,413,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	203,657,000.00	210,244,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	203,657,000.00	210,244,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,412,900.00	1,869,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,092,900.00	1,800,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	320,000.00	69,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	25,300,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	25,300,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	205,769,900.00	237,413,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	205,769,900.00	237,413,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	205,577,566.70	237,411,722.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	127,747,699.01	152,111,700.00
210101	Үндсэн цалин	89,833,899.01	125,628,000.00
210102	Нэмэгдэл	17,772,000.00	12,245,600.00
210104	Урамшуулал	11,217,000.00	14,238,100.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,924,800.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,085,099.69	19,014,000.00
210201	Тэтгэврийн даатгал	10,056,899.69	12,929,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,257,300.00	1,520,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,005,400.00	1,217,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	251,300.00	304,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,514,200.00	3,042,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,310,158.00	18,078,000.00
210301	Гэрэл, пахилгаан	5,029,801.00	4,413,925.00
210302	Түлш, халаалт	14,220,357.00	11,996,375.00
210303	Цэвэр, бохир ус	60,000.00	1,667,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,409,610.00	2,462,400.00
210401	Бичиг хэрэг	617,700.00	681,200.00
210402	Тээвэр, шатахуун	339,400.00	657,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	455,000.00	426,800.00
210404	Ном, хэвлэл	270,000.00	88,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	727,510.00	608,700.00
2105	Нормативт зардал	38,993,500.00	35,677,822.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	99,500.00	200,000.00
210502	Хоол, хунс	38,894,000.00	34,805,822.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	672,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	9,022,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	9,022,000.00

2107	Томиллолт, зочны зардал	208,000.00	300,600.00
210702	Дотоод албан томиллолт	208,000.00	300,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	410,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	230,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	823,500.00	335,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	823,500.00	335,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	192,333.30	1,578.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,578.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,578.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	192,333.30	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	192,333.30	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,300,000.00	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЫН ДҮН (5)	2,300,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,300,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	2,300,000.00	-
225106	Биет ба биет бүс хөрөнгө худалдан авсан зардал	2,300,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(2,300,000.00)	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(0.00)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	81,346,141.00	62,581,247.76	1,156,983,174.55	-	1,300,910,563.31
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	81,346,141.00	62,581,247.76	1,156,983,174.55	-	1,300,910,563.31
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн					-
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	81,346,141.00	62,581,247.76	1,156,983,174.55	-	1,300,910,563.31
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	81,346,141.00	62,581,247.76	1,156,983,174.55	-	1,300,910,563.31
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	81,346,141.00	62,581,247.76	1,156,983,174.55	-	1,300,910,563.31
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D07	Галдаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D08	Тайлант үеийн үр дүн			(36,887,417.06)		(36,887,417.06)
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	81,346,141.00	62,581,247.76	1,120,095,757.49	-	1,264,023,146.25

3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	235,544,000.00	235,542,422.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	235,544,000.00	235,542,422.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	235,544,000.00	235,542,422.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	152,111,700.00	152,111,700.00
210101	Үндсэн цалин	125,628,000.00	125,628,000.00
210102	Нэмэгдэл	12,245,600.00	12,245,600.00
210104	Урамшуулал	14,238,100.00	14,238,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,014,000.00	19,014,000.00
210201	Тэтгэврийн даатгал	12,929,800.00	12,929,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,520,900.00	1,520,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,217,000.00	1,217,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	304,000.00	304,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,042,300.00	3,042,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,078,000.00	18,078,000.00
210301	Гэрэл, цахилгаан	3,283,000.00	4,413,925.00
210302	Түлш, халаалт	13,125,000.00	11,996,375.00
210303	Цэвэр, бохир ус	1,670,000.00	1,667,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,393,100.00	2,393,100.00
210401	Бичиг хэрэг	440,400.00	611,900.00
210402	Тээвэр, шатахуун	657,600.00	657,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	480,000.00	426,800.00
210404	Ном, хэвлэл	200,000.00	88,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	615,100.00	608,700.00
2105	Нормативт зардал	35,679,400.00	35,677,822.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	200,000.00	200,000.00
210502	Хоол, хүнс	34,807,400.00	34,805,822.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	672,000.00	672,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,222,000.00	7,222,000.00
210604	Урсгал засвар	7,222,000.00	7,222,000.00
2107	Томилолт, зочны зардал	300,600.00	300,600.00
210702	Дотоод албан томилолт	300,600.00	300,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	410,000.00	410,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	230,000.00	230,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	335,200.00	335,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	335,200.00	335,200.00